



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН 2016



АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Зорилго зорилт
Компанийн дунд хугацааны стратегийн зорилт
Түүхэн замнал
Бүтэц зохион байгуулалт
Брэндүүд
Харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
Бизнесийн орчин
Онцлох үйл явдлууд
Коллекц
Санхүү, үйл ажиллагааны үзүүлэлтүүд
Санхүүгийн тайлан
Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл
Удирдлагын зардал

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Хувьцааны арилжаа
Үнэт цаасны мэдээлэл
Ногдол ашиг

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын тогтолцоо
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
ТУЗ-ийн дэргэдэх хороод
Хараат бус аудитор
Дотоод аудит
Эрх бүхий албан тушаалтан

MONGOLIAN CASHMERE

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь ХК
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолуур, тэмээний ноосонд боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх
ХК-ийн албан ёсны хаяг	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 Вэб сайт: http://www.gobi.mn И-мэйл: info@gobi.mn
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга Дамбийжавын ХҮРЭЛБААТАР Гүйцэтгэх захирал Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 09 сарын 05-ны өдөр
Ажилчдын тоо	1300
Дүрмийн сан	780,112,500 төгрөг
Гэрчилгээ, батламж	1994 онд ISO9001 “Чанарын удирдлагын тогтолцоо” 1997 онд “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх гэрчилгээ 1999 онд ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC17025:2007) стандартын шаардлага хангасан ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЛАБОРАТОРИ 1999 онд ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC17025:2007) стандартын шаардлага хангасан НЭГДСЭН ЛАБОРАТОРИ



ЗОРИЛГО ЗОРИЛТ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажиллагчдын үнэ цэнэтэй байгууллага байна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

Компанийхаа төлөө зүрх сэтгэл, бүхий л авьяас чадвараа дайчлан ажиллаж буй чадварлаг мэргэжилтэн, ажилчид
Бидэнтэй үргэлж хамт байдаг нийт хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
Дэлхийд хосгүй Монгол ноолуур
Дэлхийн дэвшилтэт технологийн үйлдвэр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Шударга, ил тод, нээлттэй
Хууль, дүрмийг чандлан сахиулна
Хүний эрхийг дээдэлнэ
Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

КОМПАНИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

БРЭНДИНГ

Зорилтот зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний сегментчилэлийг бий болгож, тансаг зэрэглэлийн бренд, ажил хэрэгч хувцасны дэд брендүүдийг хөгжүүлэх

ФРАНЧАЙЗИНГ

Франчайзингийн бодлогыг сайжруулж, гадаад зах зээлд чиглэсэн маркетингийн ажлыг нэмэгдүүлэх, гадаад дахь Говь нэрийн дэлгүүрийн тоог 100 хүргэх (Европ, Орос, АНУ, Япон, Хятад, Солонгос)

ЧАНАР

Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулж, 2015 онд шинэчилэгдэн батлагдсан ОУ-ын чанарын MNS/ ISO9001:2016 стандартыг 2017 он гэхэд нэвтрүүлэх

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулж, аюулгүй ажиллагаагаар улсын хэмжээний үлгэр жишээ компани болох, MNS/OHSAS18001:2012-ийг нэвтрүүлэх

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Улирал харгалзахгүй өмсөх ноолууран бүтээгдэхүүнийн судалгаа, хөгжүүлэлтийг хийж, ноолууран бүтээгдэхүүний шинэ зах зээл бий болгох

Дэлхийд ноолууран пальтоны үйлдвэрлэлт борлуулалтаар №1 болж тэргүүлэх

ӨРСӨЛДӨХ ЧАДВАР


Бүтээгдэхүүний чанар, загвар, дизайныг сайжруулах замаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, дотоод зах зээлд эзлэх хувиа өсгөх

ӨГӨӨЖ


Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хүчийн чадлын ашиглалтыг сайжруулах




ТҮҮХЭН ЗАМНАЛ




ТҮҮХЭН ЗАМНАЛ



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





БРЭНДҮҮД

GOBI ORGANIC

MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байглийн үндсэн 4 өнгө болох цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор өнгүүдийг ашигласан, будаагүй, цайруулаагүй, химийн ямар ч орц ороогүй Gobi Organic Cashmere бренд



АЛТАН ХОЛЬЦ

NEW COLLECTION

Японы мэргэжлийн технологичдын олон жилийн туршлага, байгалийн тансаг ширхэгтүүдийн зохимжит харьцаа, загварлаг өнгөлөг бүхний нийлбэр Golden mix бренд



Гольф сонирхогч, тамирчидад зориулан тансаг ноолуураар өнгөний гайхамшгийг хослуулан урласан GOBI GOLF бренд

SUMMER LIGHT CASHMERE

Тансаг зэрэглэлийн нарийн ноолууран утсаар сүлжиж, ноолуурын шинж чанартай гайхалтай зохицдог, тор, саан утас, торгон материалыг хослуулан, хатгамал хээгээр чимсэн дэгжин, хөнгөн Light Cashmere бренд



MAZAAHAI

MONGOLIAN CASHMERE

Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн, зөөлөн, загварлаг Мазаахай хүүхдийн бренд

ХАРИЛЦАГЧ, ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Дэлхийд танигдсан Монгол бренд” уриатай “Говь” ХК нь 1981 онд Монгол Улсын ууган үйлдвэрүүдийн нэг Говь комбинат нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан цагаасаа Монгол улсынхаа эдийн засаг, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар ирлээ.

Энэ жил манай компани үүсгэн байгуулагдсныхаа 35 жилийн ойг тэмдэглэх гэж байгаа бөгөөд түүхэн энэ жилүүдэд тус байгууллагын үе үеийн удирдлага, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд манай байгууллага өргөжин тэлж, улсын хэмжээнд нэр хүндтэй томоохон компани болон тодорсныг энд цохон тэмдэглэхэд таатай байна.

Говь ХК нь 2007 онд анх хувьчлагдахад нийт хөрөнгийн хэмжээ 27 тэрбум байсан бол эдүгээ 122.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, жилд 70 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 1300 гаруй хүнийг ажлын байраар хангасан, улсын төсөвт жилд 10 гаруй тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн үндэсний хэмжээний томоохон компани болоод байна.

Монгол улсын хосгүй үнэтэй баялаг болсон Монгол ноолуурыг дэлхийн зах зээлд бренд болгохын тулд бид бүтээгдэхүүнээ илүү загварлаг, илүү тансаг, илүү эко болгохыг зорьж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хийсээр ирсний жишээ нь бидний бий болгосон Organic cashmere(будаг, химийн бодис хэрэглээгүй), Light Cashmere(зуны ноолуур), Golden Mix(торго, хөвөнгийн хольцтой) брендүүд юм.

Бид 2015 онд хийсэн бүтээсэн амжилтаа үнэлүүлж МҮХАҮТ-аас “2015 ОНЫ ШИЛДЭГ ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОГЧ”, “ТОП-150”, ГОЁЛ-2016 наадмаас “ШИЛДЭГ ЗОХИОН БҮТЭЭХ ТОВЧОО”-ны цом өргөмжлөлүүдийг гардан авлаа.

Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлын хувиар Говь ХК-ийг зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, улсын орныхоо эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ХАРИЛЦАГЧ, АЖИЛЛАГСАДЫН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын жишиг компани байлгахыг эрхэм зорилгоо болгон ажиллах болно.

Бидний ололт амжилтыг цаг үргэлж дэмжиж байдаг та бүхэндээ сайн сайхныг хүсч, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.БААТАРСАЙХАН

БИЗНЕСИЙН ОРЧИНД ГАРСАН ЭЭРЭГ СӨРӨГ ӨӨРЧЛӨЛТҮҮД

УИХ СОНГУУЛЬ-2016

МАН-ийн мөрийн хөтөлбөрөөс:

ИМПОРТЛОГЧ ОРНООС ЭКСПОРТЛОГЧ ОРОН БОЛНО

- Импортын барааны татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ.
- Гадаад зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжиж, “Монгол экспорт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Татвар нэмэхгүй, шинээр татвар бий болгохгүй

АСЕМИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ

2016 оны долдугаар сарын 15-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтаас гарсан УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ-аас:

- Үр ашиг бүхий олон талт хамтын ажиллагааны үйл явц, эрх зүйд суурилсан олон улсын дэг журмыг тогтооход тус дөхөм үзүүлэх үүргээ бэхжүүлэх
- Үр өгөөжөө өгөхүйц хамтын ажиллагааны салбар, чиглэл бүрийн хүрээнд хэрэгжүүлэх санал санаачилга, төслүүд болон төрөл бүрийн салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах

ЯПОН-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЦЭЛ

2016 оны 6 сарын 7-оос хэрэгжиж эхэлсэн ЯПОН-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЦЭЛ


- Япон улс руу экспорт хийхэд гарал үүслийн гэрчилгээтэй бол гаалийн татвараас чөлөөлөх

ДАЯАРШИЛ

Дэлхий нийтээр даяаршиж, улс орнууд болоод бизнесүүд, хүмүүс хоорондын харилцаа, харилцан хамаарал нэмэгдэхийн хирээр улс орны болон бизнесийн хөгжлийн төвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас ХҮН, БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН хүчин зүйлийг цогц байдлаар харилцан хамааралтай авч үздэг тулхтай хөгжлийн шинэ хандлага руу хүн төрөлхтөн шилжсээр байгаа нь компаниас үйл ажиллагаандаа олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, мөрдөх шаардлагыг нэмэгдүүлж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



АСЕМИЙН ЗОЧИДЫГ ХҮЛЭЭН АВЛАА

АСЕМ-ийн чуулган болон түүний дагалдах хурал, зөвөлгөөнд хүрэлцэн ирсэн гадны томоохон зочид төлөөлөгчдийг хүлээн авч, уулзалт, үйлдвэр үзүүлэх аялал зохион байгууллаа.



ТӨРИЙН ХҮНДЭТГЭЛИЙН БЭЛГИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ

Ерөнхийлөгчийн тамгын газрын захиалгаар АСЕМ-ийн дээд хэмжээний зочидод барих төрийн хүндэтгэлийн бэлэг-ийг Говь-ийн 100% ноолууран даавуун дээр принт технологиор хийж гүйцэтгэлээ.



ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ЗАРЛАЛАА

Компани 2016 оны 6 сарын 6-ны өдөр "From GOAT to COAT" хэвлэлийн бага хурал зарлаж, таван жилийн дараа буюу 2021 гэхэд 100 хувь ноолууран пальтоны үйлдвэрлэлээрээ дэлхийд №1 тэргүүлэгч болно гэдгээ олон нийтэд зарлалаа.



ННК ТЕЛЕВИЗИЙН БАРИМТАТ НЭВТРҮҮЛЭГТ ОРОЛЦЛОО

Японы NHK телевизийн "Asia Insight" баримтат нэвтрүүлэгт оролцож, Монголын ноолуурын зах зээл болон компанийн үйл ажиллагааг танилцууллаа.

<http://www3.nhk.or.jp/nhkworld/newsroomtokyo/aired/20160530.html>



SPRING/SUMMER-2016 КОЛЛЕКЦИО ТАНИЛЦУУЛЛАА

ХААН банктай хамтран “ХААН-түншлэл” кокейл шоуг зохион байгуулж, “Spring/Summer-2016” хавар, зуны коллекцио танилцууллаа.



ЖУУЛЧДАД ЗОРИУЛСАН ЗАГВАРЫН ШОУ

Аялал жуулчлалын улирал ирсэнтэй холбогдуулан 4 сараас 8 сарыг дуустал өдөр бүр жуулчдад зориулсан загварын шоу зохион байгуулж байна.



ШИНЭ ДЭЛГҮҮРҮҮД НЭЭЛЭЭ

Гадаадад Канад, БНХАУ-д болон ОХУ-ын Казан-д, дотооддоо Шангри-ла молл, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд шинэ дэлгүүрүүд нээлээ.



“МОНГОЛ НООЛУУРЫН ЭЛЧ” ТОМИЛОО

МУ-ын ЗГ-аас Монгол ноолуурыг гадаад улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэж хувь нэмрээ оруулж буй хүмүүсийг сонгон “Монгол ноолуурын элч”-ээр өргөмжилж ирсэн. Энэ удаад Япон (Танилаг ХХК-ийн захирал Айко Сузуки), Солонгос (Женэсэкуа Интернэшнл ХХК-ийн захирал Хо Жүн Бом) улсаас шалгаруулан өргөмжиллөө.



КОЛЛЕКЦ

Цагаан сар-2016
Spring/Summer-2016
Алтан хольц
Gobi Organic 2016
Принттэй шааль
Март
Наадам




САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ҮЗҮҮЛЭЛТ	хэмжих нэгж	2016 оны эхний хагас жилийн		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төл.биелэлт (%)
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	24,977	25,065	100%
Дотоод борлуулалт	сая.төг	16,926	15,729	93%
Гадаад борлуулалт	сая.төг	8,051	9,336	116%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	15,490	15,456	100%
НИЙТ АШИГ	сая.төг	9,488	9,608	101%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	4,724	7,118	151%
Үйл ажиллагааны бус ашиг алдагдал	сая.төг	438	1,129	258%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	2,831	3,162	112%
ЭКСПОРТ	мян.USD	4,104	4,801	117%
ҮЙЛДВЭРЛЭЛТ	сая.төг	31,590	30,085	95%
Сүлжмэл	мян.шир	230	228	99%
Нэхмэл	мян.метр	135	121	89%
Оёмол	мян.шир	18	14	77%
Ээрмэл	тонн	114	126	111%
Самнасан ноолуур, ноос	тонн	116	113	97%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ	тонн	360	349	97%
АЖИЛЛАГСДЫН ДУНДАЖ ТОО	хүн	1,332	1,399	105%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	4,401	1,314	30%

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО


тэрбум төгрөгөөр

**ЦЭВЭР АШИГ**


тэрбум төгрөгөөр

**ЭКСПОРТ**

сая доллараар

**ҮЙЛДВЭРЛЭЛТ**

тэрбум төгрөгөөр




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Цэвэр ашиг
3.2
тэрбум.төг



Төлсөн татвар
4.2
тэрбум.төг



Хөрөнгө оруулалт
1.3
тэрбум.төг

ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛ



Дотоод борлуулалт
15.7
тэрбум.төг



Дотоодын зах зээлд эзлэх %
66%



Нэрийн барааны дэлгүүр
8

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



Экспорт
4.8
мян. доллар



40 орны
190+
харилцагч



Нэрийн барааны дэлгүүр

12 орны
25 хотод
55
дэлгүүр

ҮЙЛДВЭРЛЭЛТ



Сүлжмэл
228
мян.шир



Нэхмэл
121
мян.м



Оёмол
14
мян.шир

ХҮНИЙ НӨӨЦ



Ажилчдын тоо
1399



Эрэгтэй
313
Эмэгтэй
1086



6000
Хүн.цаг

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015.12.31	2016.06.30
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	18,011,348,672	1,912,561,406
Дансны авлага	3,870,001,972	6,583,702,299
Татвар, НДШ-ийн авлага	14,046,918	8,661,459
Бусад авлага	7,398,289,001	8,811,804,227
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	46,366,783,440	67,194,615,602
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8,592,029,950	1,589,442,144
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,252,499,953	86,100,787,136
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	37,984,770,596	37,350,465,696
Биет бус хөрөнгө	4,781,244	28,347,449
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,000,000	9,000,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	209,735,616	100,892,245
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	300,000,000	7,595,980,048
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,508,287,455	45,084,685,439
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	122,760,787,408	131,185,472,575
ӨР ТӨЛБӨР		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	312,229,762	305,738,694
Цалингийн өглөг	1,614,714,259	616,373,523
Татварын өр	1,605,907,947	574,350,893
НДШ-ийн өглөг	11,125,435	85,030,805
Богино хугацаат зээл	26,014,975,000	32,286,581,250
Хүүний өглөг	183,943,242	40,933,372
Ногдол ашгийн өглөг	171,931,283	951,269,653
Урьдчилж орсон орлого	478,077,825	1,893,232,081
Нөөц / өр төлбөр /	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	12,645,254	7,282,473
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	30,405,550,007	36,760,792,745
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	23,880,000,000	23,880,000,000
Нөөц / өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	23,880,000,000	23,880,000,000
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	54,285,550,007	60,640,792,745
ЭЗДИЙН ӨМЧ		
Төрийн өмч	-	-
Хувийн өмч	780,112,500	780,112,500
Хувьцаат өр төлбөр	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13,370,979,379	12,572,800,133
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Хуримтлагдсан ашиг	54,324,145,523	57,191,767,196
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	68,475,237,402	70,544,679,830
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	122,760,787,408	131,185,472,575



ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.06.30
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	71,210,860,281	25,064,925,930
Борлуулалтын өртөг	43,273,032,498	15,456,431,579
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	27,937,827,783	9,608,494,351
Түрээсийн орлого	165,914,062	82,335,459
Хүүгийн орлого	1,619,431,352	1,097,679,544
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	86,127,324	17,597,218
Борлуулалт, маркетингийн зардал	7,104,100,562	1,988,803,898
Ерөнхий ба удирдлагын зардал	9,075,641,985	4,892,871,395
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	289,546,634	236,428,443
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(149,623,127)	(68,331,190)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	462,778,138	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	13,653,166,352	3,619,671,646
Орлогын татварын зардал	2,905,283,000	458,071,718
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	10,747,883,352	3,161,599,928
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	10,747,883,352	3,161,599,928
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	6,276,052,379	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	17,023,935,730	3,161,599,928
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)	1,378	405

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.06.30
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	73,855,246,158	24,165,745,528
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	73,656,361,156	24,056,622,373
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	198,885,002	109,123,155
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-73,034,226,190	-46,026,263,654
Ажиллагчдад төлсөн	-10,262,949,353	-6,060,933,378
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-2,343,916,772	-956,550,051
Бараа материал худалдан авахад төлсөн	-40,486,925,796	-28,585,270,588
Ашиглалтын зардалд төлсөн	-1,895,618,451	-1,055,732,157
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-780,510,263	-396,188,033
Хүүний төлбөрт төлсөн	-4,038,326,951	-2,170,208,013
Татварын байгууллагад төлсөн	-2,601,188,953	-713,492,740
Даатгалын төлбөрт төлсөн	-35,589,070	-28,781,459
Бусад мөнгөн зарлага	-10,589,200,581	-6,059,107,236
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	821,019,968	-21,860,518,127
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,362,423,171	964,005,555
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	6,829,057,455	244,100
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	1,533,365,716	963,761,455
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-16,355,941,832	-1,167,403,142
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-8,958,152,832	-1,167,403,142
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-7,397,789,000	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-7,993,518,662	-203,397,587
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	17,997,926,430	7,597,000,000
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,000,000,000	7,600,000,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-2,073,570	-3,000,000
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-9,050,332,374	-1,631,871,553
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-7,957,000,001	-1,350,272,690
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-1,093,332,374	-281,598,863
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	8,947,594,056	5,965,128,447
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,775,095,362	-16,098,787,266
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	16,236,253,311	18,011,348,672
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	18,011,348,672	1,912,561,406



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2016 ОНЫ 01-Р САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	780,112,500	13,370,979,379	54,324,145,523	68,478,237,402
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	780,112,500	13,370,979,379	54,324,145,523	68,478,237,402
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,161,599,928	3,161,599,928
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-1,092,157,500	-1,092,157,500
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-798,179,245	798,179,245	-
2016 ОНЫ 06-Р САРЫН 30-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	780,112,500	12,572,800,133	57,191,767,196	70,547,679,830

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.


СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2016.Q2
Холбоотой талд өгсөн санхүүжилт	8,300,000,000
Холбоотой талаас авсан санхүүжилт	7,100,000,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	2,332,858
Холбоотой талаас авсан худалдан авалт	506,509,689
Хүүгийн орлого	499,421,923
Хүүгийн зардал	-
Түрээсийн орлого	53,672,728
Түрээсийн зардал	28,519,091

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Зардлын төрөл	Дүн
ТУЗ-ийн бүрэлдэхүүний цалин урамшуулал	55,350,000
Удирдлагуудын цалин, урамшуулал	211,317,137
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	10,160,632
НИЙТ	276,827,769

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА



“ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ:
/ 2016 оны эхний хагас жилийн/

ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО	7,801,125
ХУВЬЦААНЫ ҮНЭ	
Хувьцааны хаалтын үнэ	8,340
Хамгийн их	8,500
Хамгийн бага	7,290
АРИЛЖААЛАГДСАН ТОО	27,462
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН	222,095,825
Хувьцааны дундаж үнэ	8,087
КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	65,061,382,500

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА I АНГИЛАЛД БҮРТГЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээлэл, бусад мэдээ мэдээллээ холбогдох хууль тогтоомжид тавигдсан шаардлагын дагуу нийтэд мэдээлсэн байдал, мэдээлэл хоорондын нийцэл, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан шалгуурууд болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, хувьцааны арилжааны харьцангуй идэвхи, компанийн санхүүгийн чадавхи зэргийг харгалзан үнэт цаасны бүртгэлийн ангиллыг Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 7 сарын 20-ны өдрийн 263 тоот тушаалаар шинэчилэн тогтоосон байна.

Энэхүү шалгуураар Говь ХК үнэт цаасны бүртгэлийн II ангиллаас I ангилалд шилжлээ.



НОГДОЛ АШИГ

ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашигт тараасан /төг/
1996	61	475,868,625
1997	154	1,199,813,025
1998	150	1,170,168,750
1999	166	1,294,986,750
2000	100	780,112,500
2001	20	157,270,680
2005	60	468,067,500
2006	60	468,067,500
2010	100	780,112,500
2011	100	780,112,500
2012	125	975,140,625
2013	130	1,014,146,250
2014	140	1,092,157,500
2015	140	1,092,157,500

НООГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Говь ХК нь 2010-2014 онуудад зарласан ногдол ашгаа тухайн жилдээ багтаан Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100 % тараасан байна.

Компани 2010.03.10-ны өдрийн байдлаар Говь ХК-ийн хувьцааг эзэмшиж байсан бүх хувьцаа эзэмшигчиддээ зардлыг нь хариуцан үнэт цаасны хадгаламжийн данс нээлгэсэн бөгөөд уг дансанд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Говь хувьцаат компанийн төдийгүй бусад бүх компаниудын хувьцаа, Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан тараагдсан ногдол ашиг төвлөрч байгаа юм.

2015 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ


Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2016 оны 1 сарын 21-ны өдрийн хурлаар 2015 оны үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 140 төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 10.3 хувийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн.

2015 оны ногдол ашгийг 2016 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн компани дээрээ тарааж байгаа бөгөөд 6 сарын 30-ны өдрийн байдлаар 17 хувьцаа эзэмшигчийн 182420 төгрөгийн ногдол ашгийг тараагаад байна. Үлдсэн хэсгийг 2016 оны 10 сарын 1-нээс өмнө Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь хувьцаат компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ТОО

16,263

/2016.06.30-ны байдлаар/

Хувьцааны 5%-аас дээш багцыг эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо /мян.ш/	Эзэмшлийн хувь
HIDE INTER LLC	2,652.4	34.0%
ЭФ-СИ-АЙ ХХК	2,230.0	28.6%
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	1,239.8	15.9%
ҮЛЭМЖ ИХ ХХК	438.8	5.6%

Тайлангийн хугацаанд компанийн хувьцааны 5%-аас дээш багцыг эзэмшигчдийн эзэмшлийн хувьд өөрчлөлт ороогүй.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-аас эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2016 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 4 сарын 8 өдөр 6,688,859 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож, 85.74 хувийн ирцтэйгээр хуралдан, дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцэн 100%-ийн зөвшөөрсөн саналаар баталсан.
2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэн 100%-ийн зөвшөөрсөн саналаар баталсан. Дүрэмд дараах өөрчлөлтүүдийг оруулсан.
 - Компанийн эрх бүхий албан тушаалтанд Санхүү, бүртгэлийн хэлтсийн захирлыг нэмж оруулан, “7.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, Бизнес удирдлагын газрын захирал, Борлуулалтын газрын захирал, Үйлдвэр удирдлагын газрын захирал, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирал, Чанар стандарт баталгаажуулалтын газрын захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн захирал, Хуулийн зөвлөх зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” болгож өөрчлөх
 - Дүрмийн бүх зүйл заалтуудын дугаарлалтыг нэгдмэл нэг хэлбэрт оруулж засах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг батлах тухай асуудлыг хэлэлцэж, ердийн гишүүнээс Цагаачийн Баатарсайхан, Дашдаваагийн Хулан, Даваагийн Наранбаатар, Хидео Савада нарыг, хараат бус гишүүдээр Такеши Камбе, Түнрэвийн Одмаа, Дамбийжавын Хүрэлбаатар, Дамбын Гэрэлмаа, Зуунайн Шагдарсүрэнг нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгох шийдвэр гаргалаа .

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах , чиглүүлэх, үйл ажиллагаанд

хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлнэ. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороодыг байгуулж, тэдгээрээр дамжуулан компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл Аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа билээ. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хууль дүрэмд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэл, аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодит байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдлийн удирдлагын хэрэгжилтэнд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн үр чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

2016 оны эхний хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөл 4 удаа, Аудитын хороо 3 удаа тус тус хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд компани сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ТУЗ-ийн ажиллах журам, Эрсдэл, аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны дүрэм, хараат бус аудиторт тавигдах шалгуур, дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагааны горимууд, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлтүүд, ТУЗ-ийн өөрийгөө үнэлэх механизм, мэдээллийн нууцын журам зэргийг батлан мөрдөж байна.

Мөн хууль, журам, засаглалын кодексийн дагуу мэдээллийг ил тод болгоход анхаарч, олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг тогтмол, цаг хугацаанд нь зохих журмын дагуу хүргэж ирлээ. Цаашид эдгээр үйл ажиллагаатай холбоотой журмуудаа баталж, компанийн засаглалаар тэргүүлэгч, үлгэр жишээ компани болохыг зорьж байна.

ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын түршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэх ба хараат бус аудиторын уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн, бие даан шууд сонгох, аудитортой байгуулах гэрээг батлах, хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, гэрээг цуцлах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Говь ХК-ын Дотоод аудитын хэлтэс нь ТУЗ-ын дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд харьяалагдах бөгөөд Дотоод аудитын алба (үйл ажиллагаа), Дотоод хяналтын алба (санхүү, бүртгэл) гэсэн 2 албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Дотоод аудитын хэлтэс нь компанийн гүйцэтгэх удирдлагаас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах ба компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.

Аудитын хорооноос батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулж, шалгалтын үр дүнг аудитын хороондоо эргэж тайлагнадаг. Илэрсэн зөрчлийг арилгах, засаж залруулах арга хэмжээг тусгасан зөвлөмжүүдийг Гүйцэтгэх удирдлагад хүргүүлэх байдлаар компанийн удирдлагын багтай холбогдон эргэх холбоотой ажиллаж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Овог, нэр	Эрхэлж буй ажил	ТУЗ-ийн гишүүний статус	Хувьцааны эзэмшлийн байдал
-----------	-----------------	-------------------------	----------------------------

ХАРААТ БУС ГИШҮҮН

Дамбийжавын ХҮРЭЛБААТАР	Худалдаа Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч захирал	ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны дарга	500ш
Дамбын ГЭРЭЛМАА	СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхмийн Профессор	Нэр дэвшүүлэх хорооны дарга, Эрсдэл, аудитын хорооны гишүүн	
Түнрэвийн ОДМАА	Ланддорф финанс ББСБ-ын Гүйцэтгэх захирал	Эрсдэл, аудитын хорооны дарга	
Такешин КАМБЭ	Asahi Life Insurance компанийн Менежер	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүн	
Зуунай ШАГДАРСҮРЭН	Хуульч, Өмгөөлөгч	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	

ЕРДИЙН ГИШҮҮН

Цагаачийн БААТАРСАЙХАН	Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал, Таван богд группын Ерөнхийлөгч	Цалин урамшууллын хорооны гишүүн	Таван богд ХХК, Эф-Си-Ай ХХК, Үлэмж Их ХХК 3,908,664ш, (50.1%) 122,473ш (1.57%)
Дашдаваагийн ХУЛАН	Таван богд группын Тэргүүн дэд ерөнхийлөгч	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	
Даваагийн НАРАНБААТАР	Говь ХК-ийн Тэргүүн дэд захирал	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	
Хидео САВАДА	Н.I.S компанийн Ерөнхийлөгч	Ердийн гишүүн	Hide Inter LLC 2,652,383ш (34.00%)



БУСАД ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

Овог, нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мэргэжил, Ажлын туршлага	Хувьцааны эзэмшлийн байдал
Дугарын СОЛОНГО	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	ЭДИЙН ЗАСАГЧ ХҮДС-д Гэрээт багш, Говь ХК-д Санхүүгийн шинжээч, Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга	-
Нямжавын СҮРЭНРАГЧАА	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	ЭДИЙН ЗАСАГЧ Таванбогд трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежер	-
Лувсангийн АРИУН	Борлуулалт хариуцсан дэд захирал	МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР KVH Co.Ltd-д Маркетингийн ахлах менежер, Говь ХК-д Бодлого, журам хариуцсан менежер	-
Цэрэндондогийн БУДХҮҮ	Борлуулалтын газрын захирал	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА Монфреш ХХК, Ди Си Эйч ХХК-уудад Маркетингийн менежер, Таванбогд Смарт электроникс ХХК-д Маркетинг, борлуулалтын албаны дарга	-
Гонгорын САРУУЛЗАЯА	Үйлдвэрийн удирдлагын газрын захирал	СҮЛЖМЭЛИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Говь ХК-д Дагалдан инженер, Мастер, Төлөвлөлтийн менежер, Сүлжмэлийн үйлдвэрийн дарга	-
Батсуурийн БОЛОРМАА	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирал	ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭГЧ Дархан минж ХХК-д Дизайнер, Говь ХК-д Чанар шалгагч, Загвар зохион бүтээгч инженер, Дизайнер	-
Нямцэрэнгийн ДАВААСҮРЭН	Чанар, стандарт, баталгаажуулалтын газрын захирал	ЭЭРМЭЛИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР, НЯГТЛАН БОДОГЧ Говь ХК-д Мастер, Ерөнхий инженер, Чанарын инженер, Үйлдвэрийн дарга	-
Ганболдын СЭЛЭНГЭ	Санхүү, бүртгэлийн хэлтсийн захирал	НЯГТЛАН БОДОГЧ Улаанбаатар Принт ХХК, Таван Богд Моторс ХХК, Хаан Палас ХХК, Улаанбаатар Гурил ХХК-д Ерөнхий Нягтлан бодогч	-
Цогтбаярын ЦАСЧИХЭР	Хуулийн зөвлөх	ЭРХ ЗҮЙЧ Цагдаагийн байгууллагад мөрдөн байцаагч, "Жаст Ойл" ХХК, "М-Си-Эс" ХХК, "Таванбогд трейд" ХХК-д Хуулийн зөвлөх	-



MONGOLIAN CASHMERE

GOBI CORPORATION
INDUSTRIAL STREET, 3RD KHOROO, KHAN-UUL DISTRICT
ULAANBAATAR-17062 MONGOLIA, P.O.BOX 36/434
TEL: (976) 70139977, FAX: (976) 70143081

WWW.GOBI.MN